

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ
БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ
ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид нийцүүлэн хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолох, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасах, авлигын гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй байх, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан эсэхээс үл хамааран хурааж улсын орлого болгох, Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлгийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангаруулах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар гарах зардлын тухайд материаллаг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа тул зардал үүсэхгүй гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг D-parliament.mn цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой боловсруулсан хуулийн төсөлд хүний эрхийг хангах асуудлыг хэрхэн тусгасан, хөөн хэлэлцэх хугацаа болон хүндрүүлэх нөхцөлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд төслийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт шүүх гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, учруулсан хохирлоо төлсөн бол эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлж, эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх мөн ял шийтгэлийг сонгож болохоор тусгасан асуудлаар, түүнчлэн хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхлэхээр заах биш шууд түдгэлзүүлэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр гэмт хэргийг шуурхай илрүүлэх зорилгоор хэрэг маргааныг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэдэг төдийгүй хэргийн холбогдогч гэм буруугаа хүлээн, хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн тохиолдолд ялыг

хөнгөрүүлдэг бөгөөд энэ зохицуулалттай холбоотой авлигын гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдсэн эсэх, үр нөлөө өгч байгаа эсэх, хялбаршуулсан журмаар шийдвэрлэхгүй гэж заасан нь авлига, албан тушаалын гэмт хэрэг илрэхгүй байх эрсдэл үүсгэх эсэх, мөн авлига, албан тушаалын гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй байх талаар тусгасан нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд халдаж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Эрүүгийн хуулийн тусгай ангид заасны дагуу тодорхой гэмт хэргүүдэд бүх насаар нь хорих ял оногдуулдаг бөгөөд авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангаруулах хуулийн төслийг дэмжиж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд ялын бодлогод байгалийн баялаг тойрсон хууль бус зүйлийг хаасан зохицуулалтыг тусгаагүй, сайжруулсан зүйл харагдахгүй байгаа талаар, түүнчлэн авлига, албан тушаалын гэмт хэрэгт ялыг сонгох боломжтой байгаатай холбоотой шүүх гэмт хэрэгтэнг хөнгөн ялаар шийтгэдэг учраас зөвхөн хорих ял оногдуулдаг болгох, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяа авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангаруулах асуудлаар санал нэг байгааг илэрхийлж, гэмт хэрэг, шударга бус зүйлтэй тэмцэх нь Монгол төрийн үүрэг хэдий ч нийгэмд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулж нэг үйл явдал, нэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор боловсруулсан бол учир дутагдалтай, түүнчлэн төслийн хэлэлцүүлгийн шатанд иргэд, олон нийтийн оролцоог хангаж олон талаас нь хэлэлцэх нь зүйтэй талаар тус тус санал хэлсэн болно.


Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 71.4 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Л.МӨНХБААТАР